



ЗАХ ЗЭЭЛИЙН ТОЙМ

2018.04.09-04.13

ОЛОН УЛСЫН ЗАХ ЗЭЭЛ

АНУ: Хөрөнгө оруулагчид хувьцаат компаниудын 1-р улирлын тайлангаас илүүтэйгээр улс төрийн нөхцөл байдалд анхаарлаа хандуулсан учир энэ долоо хоногт АНУ-ын хувьцааны зах зээл тогтворгүй байлаа.

БНХАУ-ын Ерөнхийлөгч Ши Жиньпин БНХАУ-ын банк, автомашин үйлдвэрлэлийн салбарыг илүү нээлттэй болгох амлалт өгснөөр АНУ, БНХАУ хоорондын худалдааны маргаан намжив.

Мягмар гаригт болсон геополитикийн бас нэгэн онцлох үйл явдал нь АНУ-ын Ерөнхийлөгч Сирид болсон химийн зэвсэгт довтолгоонд хариу барин пуужингийн цохилт өгнө хэмээн мэдэгдсэн ба Пүрэв гаригт тус арга хэмжээ нь зайлшгүй биш гэж мэдээлснээр хувьцаануудын ханш өсжээ.

Баасан гаригт JPMorgan Chase, Wells Fargo болон Citigroup компаниудын 1-р улирлын орлогын тайлан гарч, тус компаниудын орлого унасан үзүүлэлттэй байсан ч шинжээчдийн тамгаас өндөр байв. Татварын хөнгөлөлттэй холбоотойгоор S&P 500 индексийн компаниудын орлого 17%-аар өснө хэмээн таамаглажээ.

Nasdaq индексийн өсөлтөнд гол нөлөөг Facebook компанийн хувьцааны ханш нөлөөлжээ. Хөрөнгө оруулагчид тус компанийн Гүйцэтгэх захирал болох Марк Закербергийн хоёр өдрийн турш үргэлжилсэн АНУ-ын Конгрессийн сонголд сандарч тэвдэлгүй, маш сайн оролцсон хэмээн үзсэн байна.

Түүхий газрын тосны үнэ нэмэгдэн 2014 оноос хойшхи хамгийн өндөр түвшинд хүрсэн нь S&P 500 индекст багтдаг эрчим хүчний салбарын хувьцаануудын ханшийг өсгөв.

Европ: Геополитикийн нөхцөл байдлаас үл хамааран Европын хувьцааны зах зээл өсөлттэй байлаа. Фүнтийн ханш чангарсан нь FTSE 100 индекс 1 орчим хувиар буюу бусад индексүүдээс хамгийн багаар өсөхөд нөлөөлжээ. Их Британийн үйлдвэрлэлийн бүтээгдэхүүний гарц муудсан нь зах зээлд төдийлөн нөлөөлөөгүй байна.

Япон: Энэ долоо хоногт Японы хувьцаануудын ханш өсөлттэй хаагдлаа. Иений ханш ам. долларын эсрэг 107.7 нэгж болсон нь 2017 оны сүүлээс 4.4% өндөр байна.

Ноён Харухико Курода нь Япон улсын төв банкны тэргүүнээр хоёр дох удаагаа сонгогдож байгаа ба 2013 онд анх албан үүргээ хүлээн авахдаа дефляцаас гарч, инфляцийн түвшинг 2 хувьд хүргэнэ хэмээн амлаж байсан. Ноён Курода нь төв банкны мөнгөний бодлогод ойрын хугацаанд өөрчлөлт оруулахгүй хэмээн мэдэгджээ.

ОХУ: АНУ нь ОХУ-ын албан тушаалтнууд болон ОХУ-ын 12 компанид хориг тавьснаар ОХУ-ын хувьцааны ханш сүүлийн 4 жил дэх хамгийн доод цэгтээ хүрчээ. Тус 12 компанид дэлхийн томоохон хөнгөн цагаан үйлдвэрлэгч "Русал" компани багтсан нь хөнгөн цагааны ханш өсөхөд нөлөөлсөн байна. АНУ нь ОХУ-ыг 2016 оны Ерөнхийлөгчийн сонгууль болон бусад түрэмгийлэлд оролцсон хэмээн үзэж тус улсад хориг тавьснаар Даваа гаригт ОХУ-ын МОЕХ индекс 9%-аар буурчээ. 7 хоногийн сүүлд МОЕХ индекс 4% буурч, рубль ам. долларын эсрэг 6% суларсан байна.

Олон улсын индексүүд

Индекс	Улс	Хаалт	Өөрчлөлт
MSE TOP 20	Монгол	19,429.62	-3.12 ▼
Dow Jones	АНУ	24,360.14	1.07% ▲
S&P 500	АНУ	2,656.30	0.58% ▲
Nasdaq	АНУ	7,106.65	0.61% ▲
S&P/TSX	Канад	15,273.97	-0.61% ▼
FTSE 100	Их Британи	7,264.56	2.95% ▲
S&P/ASX 200	Австрали	5,854.90	1.66% ▲
Nikkei 225	Япон	21,778.74	1.51% ▲
Hang Seng	Хонг Конг	30,808.38	2.38% ▲

Бондын өгөөж

Бонд	Валют	Купон	Үнэ
Mongol 2024 (Хуралдай)	USD	8.7%	112.48
Mongol 2023 (Гэрэгэ)	USD	5.6%	98.44
Mongol 2022 (Чингис)	USD	5.1%	97.40
Mongol 2021 (Мазаалай)	USD	10.8%	115.25
Mongol CNY (Димсам)	CNY	7.5%	100.31
DBM' 23 (Самурай)	JPY	1.5%	104.65
TDBM' 2020	USD	9.3%	107.39

Зах зээлийн хүү

Хүү	Хаалт	Үө
Libor 1M	1.896	0.00 ▼
Libor 3M	2.353	0.02 ▲
Libor 6M	2.490	0.02 ▲
Libor 1YR	2.731	0.02 ▲
US 6M Bond	1.932	0.05 ▲
US 2YR Bond	2.365	0.08 ▲
US 3YR Bond	2.508	0.09 ▲
US 5YR Bond	2.681	0.08 ▲
US 10YR Bond	2.840	0.05 ▲

Валютын ханш /төг/

Валют	2018.04.13	Өөрчлөлт
USD	2,393.93	0.10% ▲
CNY	380.96	0.44% ▲
EUR	2,954.11	1.02% ▲
RUB	38.99	-5.71% ▼
KRW	2.24	0.00% ▲
JPY	22.24	-0.13% ▼

Түүхий эдийн үнэ

Түүхий эд	Хаалт /USD/	Өөрчлөлт
Алт /spot/	1,330.93	0.41% ▲
Мөнгө /spot/	16.40	0.18% ▲
Зэс	305.20	0.88% ▲
Нүүрс	93.00	1.97% ▲
WTI газрын тос	62.25	-4.14% ▼
Brent газрын тос	67.35	-2.87% ▼
Байгалийн хий	2.68	-1.83% ▼

Макро эдийн засгийн үзүүлэлтүүд

Үзүүлэлт	Хугацаа	Хэмжээ
Инфляций түвшин	2018.11	6.90%
Бодлогын хүү	2018.11	10.00%
Банк хоорондын зах зээлийн хүү	2018.11	11.00%
Хадгаламжийн дундаж хүү /төгрөг/	2018.11	12.90%
Хадгаламжийн дундаж хүү /валют/	2018.11	5.20%
Зээлийн дундаж хүү /төгрөг/	2018.11	19.10%
Зээлийн дундаж хүү /валют/	2018.11	11.50%

Эх сурвалж: Үндэсний статистикий хороо, Монголбанк, Bloomberg

МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖИЙН АРИЛЖАА

Энэ 7 хоногт Монголын хөрөнгийн бирж дээр 42 компанийн 454.3 сая төгрөгийн 5,060,815 ширхэг хувьцаа арилжигдав.


“Ногоон хөгжил үндэсний нэгдэл” /JLT/ компанийн хувьцаа 80.77%-аар буюу хамгийн ихээр өсч 235 төгрөгт хүрч хаагдсан бол “Өндөрхаан” /ONH/ компанийн хувьцаа 14.59%-аар буурч 9,600 төгрөгт хүрч хаагдлаа.

Мөн тайлант долоо хоногт ЗГҮЦ-ны анхдагч болон хоёрдогч зах зээл дээр арилжаа хийгдээгүй.

Компанийн бондын хувьд хоёрдогч зах зээл дээр мөн л арилжаа явагдаагүй байна.


4-р сарын 13-ны өдрийн байдлаар зах зээлийн үнэлгээ 2,375.6 тэрбум төгрөгт хүрсэн бол MSE TOP-20 Индекс 19,429.62 нэгж болж өмнөх 7 хоногийн үзүүлэлтээс 3.12%-аар буурсан байна.

MSE Индекс



Эх сурвалж: MSE

Арилжааны үнийн дүн /7 хоногоор/



Эх сурвалж: MSE

Зах зээлийн хураангуй

Хураангуй	Үнийн дүн /сая төг/
Арилжигдсан үнийн дүн	454.3
Зах зээлийн үнэлгээ	2,375,635.9

Зах зээлийн индекс

Индекс	Хаалт	Өөрчлөлт
MSE Top 20	19,429.62	-3.12% ▼
MSE I индекс	9,197.72	-1.01% ▼
MSE II индекс	10,045.05	-1.39% ▼

Идэвхтэй арилжигдсан хувьцаа

Компани	Ширхэг	Үнийн дүн /төг/
ЛэндМН ББСБ	4,313,011	180,072,695
Таван Толгой	8,838	77,513,920
АПУ	93,604	55,734,984
Говь	1,840	39,681,600
Жинст-Увс	9,162	15,907,012

Өсөлттэй хувьцаа

Компани	Хаалт /төг/	Өөрчлөлт
Ногоон хөгжил үндэсний нэгдэл	235.00	80.77% ▲
Азык	2,972.00	14.97% ▲
Евроазиа капитал холдинг	1,010.00	14.37% ▲
Жинст-Увс	1,758.00	12.97% ▲
Хөх ган	110.05	9.23% ▲

Бууралттай хувьцаа

Компани	Хаалт /төг/	Өөрчлөлт
Өндөрхаан	9,600.00	-14.59% ▼
Монгол савхи	919.00	-14.59% ▼
Булган гурил тэжээл	1,275.00	-14.20% ▼
Гутал	19,000.00	-10.63% ▼
Жуулчин дюти фрий	100,500.00	-8.64% ▼

Арилжаанд идэвхтэй оролцсон үнэт цаасны компаниуд

Компани	Арилжааны үнийн дүн /төг/
Мирэ Эссет Секьюритис Монгол	135,500,719
Ти Ди Би Капитал	120,705,326
Голомт Капитал	112,675,883
БиДиСек	105,432,374
Бумбат-Алтай	82,351,724

Зах зээлийн үнэлгээ хамгийн өндөр 5 компани

Компани	Хаалт /төг/	ЗЗҮ /сая.төг/
АПУ	603.76	642,510
Таван толгой	9,040.00	476,093
МИК	10,510.00	217,654
Говь	21,980.00	171,468
Сүү	220.00	75,680

ЗГҮЦ-НЫ ХОЁРДОГЧ ЗАХ ЗЭЭЛИЙН АРИЛЖАА

№	Үнэт цаасны нэр	Арилжигдсан ширхэг	Үнийн дүн /төг/	Доод /төг/	Дээд /төг/	7 хоног	Хүү
---	-----------------	--------------------	-----------------	------------	------------	---------	-----

КОМПАНИЙН БОНДЫН ХОЁРДОГЧ ЗАХ ЗЭЭЛИЙН

№	Үнэт цаасны нэр	Арилжигдсан ширхэг	Үнийн дүн /төг/	Доод /төг/	Дээд /төг/	7 хоног	Хүү
---	-----------------	--------------------	-----------------	------------	------------	---------	-----

НОГДОЛ АШИГ ЗАРЛАСАН ХУВЬЦААТ КОМПАНИУД

№	Симбол	Компанийн нэр	Нийт ногдол ашиг /сая төг/	Нэгж хувьцаанд ногдох ашиг /төг/	Шийдвэр огноо	Бүртгэлийн өдөр	Хуваарилах өдөр
1	TTL	Таван Толгой ХК	ХЭХ-аар тогтооно		2018.03.16	2018.04.03	N/A
2	DSS	Дархан Сэлэнгийн Цахилгаан Түгээх Сүлжээ ХК	587.7	56.6	2018.03.07	2018.03.27	2018.07.02-с
3	AEL	Анд-Энерги ХК	13.3	0.5	2018.02.24	2018.03.16	N/A
4	SUL	Жуулчин дүти фрий ХК	653.6	10,000.0	2018.02.23	2018.04.11	2018.05.01-с
5	SUU	Сүү ХК	1,032.0	3.0	2018.02.14	2018.04.05	2018.12.31-ний дотор
6	GTL	Гутал ХК	2,055.7	1,270.0	2018.02.19	2018.03.18	2018.07.06-с
7	BNG	Баянгол Зочид буудал ХК	150.2	355.0	2018.02.19	2018.04.06	2018.09.01-с
8	APU	АПУ ХК	10,641.8	10.0	2018.02.19	2018.03.29	2018.06.01-ний дотор
9	BTG	Баянтээг ХК	25.3	100.0	2018.02.19	2018.03.12	2018.06.01-ний дотор
10	MIE	Материалимпекс ХК	13.7	10.0	2018.02.19	2018.03.26	2018.12.31-ний дотор
11	MNP	Монгол шуудан ХК	367.2	3.7	2018.02.13	2018.04.13	2018.05.01-с
12	MMX	Махимпекс ХК	380.1	100.0	2018.02.13	2018.04.05	2018.10.01-с
13	TCK	Талх чихэр ХК	174.0	170.0	2018.02.12	2018.04.06	2018.07.01-с
14	GHC	Ган Хийц ХК	24.2	100.0	2018.02.09	N/A	N/A
15	ADL	Адуун чулуун ХК	409.6	130.0	2018.01.24	2018.03.01	N/A
16	UBH	Улаанбаатар хивс ХК	40.4	100.0	2018.02.05	2018.02.26	2018.05.01-ний дотор
17	ТАН	Тахь-ко ХК	128.5	108.0	2018.02.05	2018.03.30	2018.05.01-ний дотор
18	GOV	Говь ХК	1,716.2	220.0	2018.02.02	2018.03.27	2018.04.24-с
19	HRM	Гермес Центр ХК	392.7	5.0	2018.01.24	2018.02.15	2018.03.06-с

ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ХУРАЛ ЗАРЛАСАН ХУВЬЦААТ

№	Симбол	Компанийн нэр	Бүртгэл	Хуралдах өдөр		№	Симбол	Компанийн нэр	Бүртгэл	Хуралдах өдөр	
1	DAZ	Дорнод авто зам	2018.03.12	2018.04.09	15:00	13	HTS	Хөтөлийн цемент шохой	2018.03.28	2018.04.16	10:00
2	GTL	Гутал	2018.03.18	2018.04.09	15:00	14	HUV	Хөвсгөл геологи	2018.03.29	2018.04.17	10:00
3	HUZ	Хөвсгөл усан зам	2018.02.26	2018.04.09	-	15	GOV	Говь	2018.03.27	2018.04.17	14:00
4	UBH	Улаанбаатар хивс	2018.02.26	2018.04.10	11:00	16	HVL	Хөвсгөл	2018.03.28	2018.04.17	14:00
5	OLL	Оллоо	2018.03.19	2018.04.10	14:00	17	HNS	Хөвсгөл хүнс	2018.03.28	2018.04.17	17:00
6	ALI	Стандарт Ноос	2018.02.26	2018.04.10	15:00	18	TGS	Номин Хишиг	2018.03.29	2018.04.18	10:00
7	HRL	Хэрлэн хивс	2018.03.19	2018.04.10	-	19	SOR	Сор	2018.03.28	2018.04.18	10:00
8	ETR	Э-Транс ложистикс	2018.03.23	2018.04.11	10:00	20	ARH	Сэлэнгэ Ар Хөвч	2018.03.30	2018.04.18	14:00
9	HUN	Увс хүнс	2018.03.23	2018.04.13	9:00	21	HHN	Хархорин	2018.03.30	2018.04.18	14:00
10	BRC	Барилга Корпораци	2018.03.16	2018.04.14	10:00	22	MIE	Материалимпекс	2018.03.26	2018.04.20	10:30
11	DBL	Даваанбулаг	2018.03.24	2018.04.14	14:00	23	TAV	Тав	2018.03.28	2018.04.20	11:00
12	TEX	Техник импорт	2018.03.28	2018.04.16	15:00						

№	Сим бол	Компанийн нэр	Бүртгэл	Хуралдах өдөр		№	Сим бол	Компанийн нэр	Бүртгэл	Хуралдах өдөр	
24	APU	АПУ ХК	2018.03.29	2018.04.20	15:00	70	JLT	Ногоон хөгжил үндэсний нэгдэл	2018.03.22	2018.04.28	14:00
25	NOG	Ачит Алкабы	2018.03.27	2018.04.20	15:00	71	TUS	Түшиг Уул	2018.03.29	2018.04.28	14:00
26	DSS	Дархан Сэлэнгийн цахилгаан түгээх сүлжээ	2018.03.27	2018.04.20	16:00	72	MOG	Монгео	2018.04.09	2018.04.29	9:00
27	HSG	Хөсөг трейд	2018.03.23	2018.04.21	12:00	73	HCH	Е-Моние	2018.04.08	2018.04.29	11:00
28	AEL	Анд-Энерги	2018.03.16	2018.04.21	12:00	74	HBZ	Хүннү менежмен	2018.04.08	2018.04.29	11:00
29	CHR	Увс Чацаргана	2018.03.23	2018.04.22	11:00	75	DAR	Дархан гурил тэжээл	2018.04.10	2018.04.29	13:00
30	BNB	Баялаг Налайх	2018.03.30	2018.04.22	15:00	76	DOT	Дорнод тээвэр	2018.04.08	2018.04.29	14:00
31	BDS	Би Ди Сек	2018.04.02	2018.04.23	10:00	77	TVT	Хар тарвагатай	2018.04.09	2018.04.29	15:00
32	SDT	Хот девелопмент	2018.04.03	2018.04.23	10:00	78	HSR	Хасу-Мандал	2018.03.23	2018.04.29	15:00
33	BEU	Бэрх Уул	2018.04.03	2018.04.23	12:00	79	SUL	Жуулчин дюти фрии	2018.04.11	2018.04.30	10:00
34	MNS	Монноос	2018.03.31	2018.04.23	15:00	80	DMA	Дэвшил Мандал	2018.04.06	2018.04.30	9:00
35	UYN	Монгол савхи	2018.04.05	2018.04.24	10:00	81	NXE	Нэхээсгүй эдлэл	2018.04.06	2018.04.30	9:00
36	JGV	Жуулчин говь	2018.04.05	2018.04.24	13:00	82	ALA	Алтайн Нэгдэл	2018.03.30	2018.04.30	10:00
37	MNG	Мандал говь импекс	2018.04.05	2018.04.24	15:00	83	BAZ	Люкс зананду групп	2018.04.06	2018.04.30	10:00
38	BHG	Бөхөг	2018.03.23	2018.04.25	10:00	84	MIK	МИК Холдинг	2018.04.11	2018.04.30	10:00
39	TAN	Тахь-ко	2018.03.30	2018.04.25	10:00	85	MNP	Монгол шуудан	2018.04.13	2018.04.30	10:00
40	BBD	Стандарт проперти групп	2018.04.10	2018.04.25	11:00	86	TMZ	Төмрийн завод	2018.04.09	2018.04.30	10:00
41	BUK	УБ-БУК	2018.04.03	2018.04.25	11:00	87	NRS	Шинэст	2018.04.10	2018.04.30	10:00
42	BDL	Могойн гол	2018.04.04	2018.04.25	12:00	88	BAN	Багануур	2018.04.13	2018.04.30	11:00
43	EER	Ариг гал	2018.04.02	2018.04.25	17:00	89	GTJ	Булган гурил тэжээл	2018.04.06	2018.04.30	11:00
44	HJL	Орхон хөгжил	2018.04.03	2018.04.25	-	90	BLC	Бүтээлч үйлс	2018.04.05	2018.04.30	11:00
45	MMX	Махимпекс	2018.04.05	2018.04.26	14:00	91	JGL	Говийн өндөр	2018.04.09	2018.04.30	11:00
46	TTL	Таван Толгой	2018.04.03	2018.04.26	14:00	92	MCH	Монголын цахилгаан холбоо	2018.04.06	2018.04.30	11:00
47	SHG	Шарын гол	2018.04.02	2018.04.26	15:30	93	RMC	Ремикон	2018.04.12	2018.04.30	11:00
48	BNG	Баянго зочид буудал	2018.04.06	2018.04.26	16:00	94	SOH	Уужим Хангай	2018.04.12	2018.04.30	11:00
49	MBG	Мон-Ит Булигаар	2018.04.05	2018.04.27	9:00	95	EAZ	Эрдэнэт авто зам	2018.04.06	2018.04.30	11:00
50	JTB	Женко Тур Бюро	2018.04.04	2018.04.27	10:00	96	BAJ	Баялаг-Сүмбэр	2018.04.12	2018.05.01	11:00
51	UID	Улсын их дэлгүүр	2018.03.30	2018.04.27	10:00	97	NKT	Нако Түлш	2018.04.03	2018.04.30	12:00
52	BUN	Булган ундрага	2018.04.06	2018.04.27	11:00	98	АНН	Хорин хоёрдугаар бааз	2018.03.23	2018.04.30	13:00
53	ERS	Монгол алт	2018.04.05	2018.04.27	11:00	99	HZB	Ган хэрлэн	2018.04.06	2018.04.30	14:00
54	MNH	Монгол Нэхмэл	2018.03.30	2018.04.27	11:00	100	INT	Ингэттолгой	2018.04.09	2018.04.30	14:00
55	MIB	Монинжбар	2018.03.20	2018.04.27	11:00	101	MSH	Монгол шилтгээн	2018.04.06	2018.04.30	14:00
56	CHE	Хорго Хайрхан	2018.04.06	2018.04.27	11:00	102	HBO	Хай би ойл	2018.04.10	2018.04.30	14:00
57	SUN	Евроази капитал холдинг	2018.03.20	2018.04.27	12:00	103	HGN	Хөх ган	2018.04.06	2018.04.30	14:00
58	BOE	Эрчим баян өлгий	2018.04.05	2018.04.27	12:00	104	SHV	Шивээ овоо	2018.04.05	2018.04.30	14:00
59	ALD	Азык	2018.03.28	2018.04.27	14:00	105	JRG	Эвлэл	2018.04.09	2018.04.30	14:00
60	ATR	Атар-Өргөө	2018.04.10	2018.04.27	14:00	106	TAS	Эрдэнэт хүнс	2018.03.31	2018.04.30	14:00
61	DZG	Дархан зочид буудал	2018.03.28	2018.04.27	14:00	107	ITLS	Айтүүлс	2018.04.06	2018.04.30	15:00
62	GFG	Силк нэт	2018.03.20	2018.04.27	14:00	108	GUR	Гурил	2018.04.07	2018.04.30	15:00
63	TCK	Талх Чихэр	2018.04.06	2018.04.27	14:00	109	SUU	Сүү	2018.04.05	2018.04.30	15:00
64	TEE	Тээвэр дархан	2018.04.05	2018.04.27	14:00	110	MDR	Фронттиер лэнд групп	2018.04.06	2018.04.30	15:00
65	DHU	Дархан Хүнс	2018.04.05	2018.04.27	14:00	111	HAM	Монголын хөгжил үндэсний нэгдэл	2018.04.09	2018.04.30	17:00
66	MRX	Мерекс	2018.04.07	2018.04.28	10:00	112	BSKY	Блюскай секьюритиз	2018.03.30	2018.04.30	18:00
67	ECV	Эрээнцав	2018.04.09	2018.04.28	11:00	113	ONH	Өндөрхаан	2018.04.12	2018.04.30	13:00
68	AMT	Хар хорум пропертийс	2018.04.09	2018.04.28	12:00	114	HTS	Хөтөлийн цемент шохой	2018.04.17	2018.05.07	10:00
69	MBG	Жинст-Увс	2018.04.12	2018.04.28	14:00	115	LND	ЛендМН ББСБ	2018.04.11	2018.05.10	18:00

ХӨРӨНГИЙН ЗАХ ЗЭЭЛИЙН МЭДЭЭ

“ЛэндМН ББСБ” ХК нь хувьцаагаа эргүүлэн худалдаж авах асуудлыг хувьцаа эзэмшигчдийн ээлжит бус хурлаар хэлэлцэх асуудлын жагсаалтаас хаслаа

“Монголын хөрөнгийн бирж” ТӨХК-д бүртгэлтэй “ЛэндМН ББСБ” ХК нь хувьцаа эзэмшигчийн ээлжит бус хурлаа 2018 оны 5 дугаар сарын 10-ны өдөр хуралдуулахаар зарласан ба уг хурлаар хэлэлцэх асуудлын жагсаалтанд “Компани өөрийн хувьцаагаа эргүүлэн худалдан авах эрхийг зөвшөөрөх эсэх” асуудлыг тусгасан байсан.

Компанийн тухай хуулийн 33.7-д заасны дагуу, компани өөрийн гаргасан хувьцааг эргүүлэн худалдан авсан тохиолдолд тус хувьцаа нь компанийн зарласан боловч гаргаагүй хувьцаанд тооцогдох ба ийнхүү гаргасан хувьцааны тоог бууруулах нь МХБ-ийн үнэт цаасны бүртгэлийн III ангиллын шалгуурыг үл хангах нөхцөл үүсэх тухай “Монголын хөрөнгийн бирж” ТӨХК-иас “ЛэндМН ББСБ” ХК-д албан бичгээр мэдэгдсэний дагуу уг асуудлыг 2018 оны 5 дугаар сарын 10-ны өдрийн хувьцаа эзэмшигчдийн ээлжит бус хурлаар хэлэлцэх асуудлын жагсаалтаас хассан байна.

Эх сурвалж: MSE.mn

“Монголын цахилгаан холбоо” ХК-ийн үнэт цаасны багцын арилжаа явагдана

Монгол Улсын Засгийн Газар болон БНСУ-ын “Кореа Телеком” ХК-ийн хооронд байгуулагдсан гэрээний дагуу Монголын хөрөнгийн биржийн үнэт цаасны 2-р ангилалд бүртгэлтэй “Монголын Цахилгаан Холбоо” ХК-ийн 40 хувийг Монгол Улсын Засгийн газарт худалдах багцын арилжааг Монголын хөрөнгийн биржээр дамжуулан зохион байгуулахаар боллоо.

“Монголын Цахилгаан Холбоо” ХК нь 1921 онд байгуулагдсан Монгол улсын ууган компани бөгөөд эрх бүхий байгууллагаас олгосон лицензийн хүрээнд төв, орон нутагт улс, хот хоорондын цахилгаан холбоо, интернэт, кабелийн телевиз, лавлах үйлчилгээг үзүүлдэг. Тус компанийн нийт хувьцааны 54.67 хувийг Монгол Улсын Засгийн газар, 40.0 хувийг Бүгд Найрамдах Солонгос улсын Кореа Телеком компани, үлдэх 5.33 хувийг Монгол Улсын болон гадаадын иргэд, аж ахуйн нэгж тус тус эзэмшдэг байна. Ийнхүү багцын арилжааг явуулснаар, “Монголын Цахилгаан Холбоо” ХК дахь Монгол Улсын Засгийн газрын эзэмшлийн хувь нь 94.67 хувьд хүрнэ.

Эх сурвалж: MSE.mn

Ган хийц ХК: 2017 онд алдагдалтай ажилласан ч 24.2 сая төгрөгийн ногдол ашиг олгоно

“Ган хийц” компани 2018 онд борлуулалтын орлогоо нэмэгдүүлж, 2.1 тэрбум төгрөгт хүргэхээр төлөвлөөд байна. 2017 онд тус компани 240 тонн төмөр хийц эдлэл үйлдвэрлэж, 1.6 тэрбум төгрөгийн борлуулалтын орлоготой ажиллажээ. Тус компани энэ онд Налайх дүүрэгт төмөр замын төмөр бетон дэр, өндөр хүчдэлийн тулгуур, сэндвич хавтангийн үйлдвэр байгуулахаар төлөвлөсөн байна. Энэхүү төсөлд нийт 32 тэрбум төгрөгийн хөрөнгө оруулалт шаардлагатай бөгөөд эхний ээлжид 11 тэрбум төгрөгөөр үйлдвэрүүдийг барихаар төлөвлөсөн талаар “Ган хийц” компани мэдээллээ. Үйлдвэр нь жилд 3000 ширхэг хүчитгэсэн бетон тулгуур, 300-350 мянган төмөр бетон дэр үйлдвэрлэх хүчин чадалтай юм байна. “Ган хийц” компани үйлдвэрийн тоног, төхөөрөмжийг шинэчлэх болон хэрэгжүүлж байгаа төслүүддээ шаардлагатай хөрөнгө оруулалтыг хөрөнгийн заххаас татах боломжийг судлахаар болжээ. Тус компани 2017 онд алдагдалтай ажилласан ч Төлөөлөн удирдах зөвлөлөөс хувьцаа эзэмшигчдэдээ нэгж хувьцаанд 100 төгрөг буюу 24.2 сая төгрөгийн ногдол ашиг олгохоор шийдвэрлэсэн байна.

Эх сурвалж: BloombergTv.mn

“Стандарт ноос” компани энэ онд 300 тонн ноос бэлтгэнэ

“Стандарт ноос” компани энэ онд малчдаас нийт 300 тонн ноос бэлтгэхээр төлөвлөөд байна. Тус компани ноос угаах үйлдвэрийн тоног, төхөөрөмжөө бүрэн суурилуулж, шинээр агуулахын байр барьснаар 1000 тонн ноос бэлтгэн угаах хүчин чадалтай болох талаар marketinfo.mn мэдээллээ. “Стандарт ноос” компани 2017 онд Баянхонгор аймгаас 122 тонн ноос бэлтгэн анхан шатны боловсруулалт хийж “Улаанбаатар хивс” компанид нийлүүлсэн байна. Энэ онд төлөвлөгөөгөө биелүүлэхэд санхүүжилтийн асуудлыг шийдвэрлэх болон ченжүүдийн ноос худалдан авалт нөлөөлнө гэж тус компани мэдэгджээ. “Стандарт ноос” компанийн хувьцааны ханш 2014 онд 780 төгрөгт хүрч өсөж байсан юм. Харин сүүлд буюу хоёрдугаар сард ханш нь 500 төгрөг байжээ.

“Стандарт ноос” компанийн 67.3 хувийг нэг хувьцаа эзэмшигч, харин 32.7 хувийг олон нийт буюу 539 жижиг хувьцаа эзэмшигч эзэмшдэг. Тус компани анх “Арилжаа импекс” ХК нэртэйгээр Баянхонгор аймагт материал-техникийн хангамжийн баазын чиглэлээр үйл ажиллагаа явуулж байжээ. Харин 2016 онд нэрээ “Стандарт ноос” болгон өөрчилж, ноос бэлтгэл, угаах үйлдвэрийн чиглэлээр үйл ажиллагаа явуулах болсон байна.

Эх сурвалж: BloombergTv.mn



Анд энерги ХК: 2018 оны эхний улиралд борлуулалт 24 хувиар өсөв

Монголын Үнэт цаасны биржид бүртгэлтэй “Анд энерги” компанийн борлуулалт энэ оны эхний улиралд өмнөх оны мөн үеэс 24 хувиар өссөн байна. Тодруулбал, нийт 5.5 мянган ширхэг лед гэрэл, гэрэлтүүлгийг үйлдвэрлэж, 2.2 мянган ширхэг бүтээгдэхүүн борлуулжээ. Тус компани I улиралд “Шарын гол”, “Улаанбаатар төмөр зам” зэрэг томоохон компаниудтай бүтээгдэхүүн нийлүүлэх гэрээ хийсэн талаар мэдээллээ. Цаашид борлуулалтаа нэмэгдүүлэхийн тулд Монголын бусад томоохон аж ахуйн нэгжүүдтэй хамтран ажиллахаар зорьж байгаа талаар “Анд энерги” компанийн Гүйцэтгэх захирал онцолж байна. Түүнчлэн тус компани зах зээлээ нэмэгдүүлэх зорилгоор Улаанбаатар хотод дэлгүүрээ нээнэ гэдгээ мэдээллээ. Тус компанийн шинэ үйлдвэрийн барилга барих ажил энэ сарын эцсээр эхлэх ажээ.

Хувьцааны арилжааг харвал 3 дугаар сард нийт 39.4 сая төгрөгийн арилжаа хийгдсэн нь өмнөх сараас гурав дахин өндөр дүн болсон байна. Мөн хувьцааных нь ханш 50 төгрөгт хүрч он гарснаас хойших дээд цэгтээ хүрчээ. “Анд энерги” компанийн хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурал энэ сарын 21-нд болох товтой байгаа юм.

Эх сурвалж: BloombergTv.mn

ТҮҮХИЙ ЭДИЙН ЗАХ ЗЭЭЛИЙН МЭДЭЭ

Rio Tinto: “Оюу Толгой”-ийн зэсийн баяжмалыг Япон, БНСУ-д экспортлоход төлөвлөсөн

“Оюу Толгой”-ийн гүний уурхайн олборлолтыг эхэлсний дараа зэсийн баяжмалыг Япон, БНСУ-д экспортлох боломжийг эрэлхийлж, төлөвлөж байгаа гэдгийг “Rio Tinto” группийн жил тутмын уулзалтын үеэр дурдсан байна. “Оюу Толгой”-ийн хөрөнгө оруулалттай холбоотой бүх гэрээний үндсэн зарчмуудын хэрэгжилттэй холбоотойгоор Монгол Улсын Парламентаас байгуулсан ажлын хэсэгтэй яриа хэлэлцээ хийнэ гэж харж байгаа талаар “Rio Tinto”-ийн Гүйцэтгэх захирал Жан-Себастьян Жак онцолжээ. Мөн тэрбээр “Оюу Толгой”-ийн хөрөнгө оруулалтын хамрах хүрээ нь оролцогч талууд болох Монгол Улс болон хувь нийлүүлэгчдэд аль алинд нь эн тэнцүү, шударга байдлаар байгуулагдсан гэдэгт итгэж байгаагаа илэрхийллээ.

Эргэн сануулахад, УИХ-ын даргын захирамжаар байгуулагдсан ажлын хэсэг “Оюу Толгой”-ийн хөрөнгө оруулалтын гэрээний хэрэгжилтийг шалгаж, хоёр сарын дотор дүгнэлтээ гаргах товтой байгаа юм. Харин олон улсын тухайд АНУ ОХУ-ын эсрэг хориг тавьсантай холбоотойгоор ОХУ-ын “Rusal” компанитай Квинслэнд мужид хамтран хэрэгжүүлэх төслөө эргэн харна гэж мэдэгдсэн байна.

Эх сурвалж: BloombergTv.mn

ҮСХ: Нүүрсний экспорт өмнөх зургадугаар сараас хойших дээд түвшинд хүрвэ

Үндэсний статистикийн хорооны мэдээлснээр Монгол улс энэ оны эхний улирлын байдлаар 1.5 тэрбум ам.долларын бараа бүтээгдэхүүн экспортолж, 1.1 тэрбум долларын бараа импортоор худалдан авсан байна. Экспортын хэмжээ өмнөх оныхоос 14%-иар буюу 182.5 сая доллараар өссөн бөгөөд үүнд алтны экспорт 80.6 сая доллар, үнэт, хагас үнэт чулуу, метал гоёлын зүйлсийн экспорт 80.8 сая доллараар өссөн нь голлон нөлөөлжээ.

Импортын хувьд өмнөх оны мөн үеийнхээс 45.6%-иар буюу 354.2 сая доллараар өсөхөд эрдэс бүтээгдэхүүний импорт 86.8 сая ам.доллар, машин, механик төхөөрөмж, цахилгаан хэрэгсэл ба тэдгээрийн сэлбэг 75.8 сая доллар, тээврийн хэрэгсэл ба тэдгээрийн эд анги 57.7 сая доллар, үндсэн төмөрлөг зүйлсийн импорт 43.3 сая доллараар тус тус өссөн нь нөлөөлжээ.

Манай улсын гадаад худалдааны тэнцэл эхний улиралд ашигтай гарсан ч өмнөх оны мөн үеийнхтэй харьцуулахад 32.8%-иар буурч 351.9 сая долларын ашигтай гарчээ.

Эрдэс бүтээгдэхүүний экспорт оны эхний улиралд 1.25 тэрбум долларт хүрч, нийт экспортын 84.5 орчим хувийг эзэллээ. Өмнөх оны мөн үетэй харьцуулахад эрдсийн экспорт энэ оны эхний улирлын байдлаар 8%-иар өсөөд байна. Энэ дундаа нүүрсний экспорт мөнгөн дүнгээр 514.5 сая долларт хүрсэн нь эрдсийн экспортын 41%, нийт экспортын 34.7%-ийг бүрдүүлсэн байна. Гуравдугаар сарын нүүрсний экспортыг дангаар авч үзвэл 3.52 сая тонн болж өмнөх хоёрдугаар сарынхаасаа 2267.8 мянган тонноор буюу 181%-иар нэмэгдсэн байна. Энэхүү биет жингийн үзүүлэлт нь өмнөх оны зургадугаар сараас хойших хамгийн өндөр үзүүлэлт боллоо. Ийнхүү биет хэмжээ гуравдугаар сард нэмэгдсэн бол орлогын дүн ч мөн өмнөх сарынхаасаа 162 сая ам.доллараар буюу 151%-иар өсч 269.1 сая ам.доллартай тэнцлээ. Энэ нь мөн өмнөх зургадугаар сараас хойших орлогын хамгийн өндөр дүн юм.



Гэхдээ эхний улирлын дүнгээрээ нүүрсний экспортын хэмжээ өмнөх оны мөн үеийнхтэй харьцуулахад мөн л доогуур байна. Нүүрсний экспортын хэмжээ биет жингээр эхний улиралд 6.77 сая орчим тонн байгаа нь өмнөх оны мөн үеийнхээс 16.8%-иар, мөнгөн дүн 514.5 сая доллар байгаа нь 4.9%-иар тус тус бууралттай байгааг харуулна. Бас нэг зүйл гэвэл өнгөрсөн сард экспортын орлого бүрдүүлэх хэмжээгээр зэс нүүрсийг давчихаад байсан бол гуравдугаар сараас эхлэн нүүрс даагаа нэхэн зэсийн урд орлоо.

Зэсийн баяжмалын экспортын борлуулалт мөн хугацаанд 337.7 мянган тонн буюу 462.5 сая доллараар илэрхийлэгдлээ. Энэ нь жингийн үзүүлэлтээр өмнөх оны мөн үеийнхээс 7.7%-иар доошилсон ч үнийн дүнгээр 21.6%-иар ахисан үзүүлэлт боллоо. Харин цэвэр зэсийн экспортын тухайд эхний улирлын байдлаар борлуулалт жингээр 3.5 орчим мянган тонн, үнийн дүнгээр 23.6 сая орчим доллартай тэнцсэн нь биет үзүүлэлт өмнөх оны мөн үеийнхээс 14.7%-иар доогуур байгаа бол орлого нь 2.5%-иар өссөн дүнтэй гарлаа.

Алтны хувьд экспортын үзүүлэлт гойд гэмээр сайн үзүүлэлттэй байгаа юм. Тайланд өгүүлсэн хугацаанд манай улс 2.9 тонн алт экспортолж, 124.3 сая доллар олсон нь өмнөх оны мөн үетэй жишихэд биет жингээр 2.7 дахин, үнийн дүнгээр 2.8 дахин огцом дээшилсэн байна.

Түүхий газрын тосны экспорт мөн хугацаанд 1.63 сая баррельд хүрч, 101 сая доллартай тэнцсэн нь жингийн тухайд 11.3%-иар буурсан ч үнийн дүнгээр 8.5%-иар нэмэгдсэн үзүүлэлттэй гарлаа.

Төмрийн хүдрийн экспортын дүн эхний улирлын байдлаар жингийн хувьд нэлээд өссөн ч орлогын үзүүлэлт бууралттай гарлаа. Тодруулбал, оны эхний улиралд манай улс 1.44 сая тонн хүдэр экспортлоод байгаа нь өмнөх оны мөн үеийнхээс 30.2%-иар өссөн ч орлогын дүн нь харин 8.9%-иар багасч, 63.9 сая доллартай тэнцэв.

Цайрын хүдэр, баяжмалын экспортын өсөлт бараг 50%-д хүрсэн сайн үзүүлэлттэй гарлаа. Эхний улирлын дүнгээр цайрын баяжмалын борлуулалт жингээр 32.9 мянган тонн байсан нь өмнөх оны мөн үеийнхээс 20%-иар нэмэгдэж, улмаар орлогын дүн нь даруй 49.3%-иар өсч, 60.2 сая орчим долларт хүрлээ.

Жоншны хүдэр, баяжмалын экспортын тухайд ч мөн адил өндөр өсөлт тохиогоод байна. Жоншны экспортын борлуулалт жингээр мөн хугацаанд 78.3 мянган тонн байсан нь өмнөх оны мөн үеийнхээс 47.3%-иар өссөн бол орлого нь 2.1 дахин нэмэгдэж, 25 сая доллартай тэнцлээ.

Хар тугалгын хүдэр, баяжмалын экспорт оны эхний улирлын байдлаар 4.02 мянган тоннд хүрч 10.64 сая долларын үнийн дүнгээр илэрхийлэгдэж буй нь өмнөх оны мөн үеийнхээс жингээр 1.6%, үнийн дүнгээр 2.2%-иар өссөн үзүүлэлт боллоо.

Молибденийн баяжмалын экспортын биет хэмжээ 1.4 мянган тоннд хүрсэн нь 18.6%-ийн бууралттай үзүүлэлт ч гэлээ орлогын дүн нь 17.3%-иар өсч 10.1 сая долларт хүрсэн байна.

Эх сурвалж: MongolianMiningJournal.com

БУСАД МЭДЭЭ

АХБ: 2018 онд Монгол Улсын ДНБ-ий өсөлт өмнөх оноос саарч, 3.8 хувь болно

Монгол Улсын эдийн засгийн өсөлт 2018 онд өмнөх оноос саарч, 3.8 хувь болно гэж Азийн Хөгжлийн банк тооцоолжээ. Харин 2019 онд өсөлт эрчимжиж, 4.3 хувьд хүрэх төлөвтэй байна. Уул уурхайн салбарын хөрөнгө оруулалт, ялангуяа “Оюу Толгой”-ийн далд уурхайн бүтээн байгуулалт нь өсөлтийг дэмжих гол хүчин зүйл байна гэж Азийн Хөгжлийн банк тайланд онцолжээ. Олон Улсын Валютын Сантай хамтран хэрэгжүүлж байгаа хөтөлбөрийн гүйцэтгэл төсөөлснөөс илүү сайн байгаа нь хөрөнгө оруулагчдын итгэлийг сэргээж байна. Мөн макро эдийн засгийн тогтвортой байдлыг сайжруулахад түлхэц болж байгааг мэдээллээ. 2017 онд хуурайшилт ихтэй байснаас хөдөө аж ахуйн бүтээгдэхүүний үнэ өссөн, зарим татварууд нэмэгдсэн зэргээс шалтгаалж инфляцын түвшин 4.3 хувь болж өсөж байсан юм. Үнийн өсөлт 2018 онд эрчимжиж, инфляц найман хувьд хүрнэ гэж Азийн Хөгжлийн банк таамаглажээ.

Олон Улсын Валютын Сангийн танилцуулснаар эдийн засгийн өсөлт 2018 онд таван хувь, 2019 онд 6.3 хувьд хүрч магадгүй байна. Мөн Дэлхийн банк дотоодын нийт бүтээгдэхүүний өсөлт энэ онд 3.1 хувьд хүрнэ гэсэн тооцооллыг танилцуулаад байгаа юм.

Харин “Fitch Group”-ийн харьяа “BMI Research”-ийн шинжээчдийн мэдээлснээр дотоодын нийт бүтээгдэхүүн 2018-2020 онд жилд дунджаар 6.6 хувиар өсөх төлөвтэй байна. 2018-2020 оны төлөвийг өмнө нь 5.8 хувь байсныг ийнхүү нэмэгдүүлээд байгаа ажээ.

Эх сурвалж: BloombergTV.mn

ҮСХ: Монгол улсын 1-р улирлын макро эдийн засгийн зарим үзүүлэлтүүд

Мөнгөний нийлүүлэлт (M2) 2018 оны 3 дугаар сарын эцэст 16.1 их наяд төгрөг болж, өмнөх сараас 164.6 (1.0%) тэрбум төгрөг, өмнөх оны мөн үеэс 3.8 (31.1%) их наяд төгрөгөөр өссөн байна.

Аж ахуйн нэгж, байгууллага, иргэдэд олгосон нийт зээлийн өрийн үлдэгдэл 2018 оны 3 дугаар сарын эцэст 14.1 их наяд төгрөг болж, өмнөх сараас 314.1 (2.3%) тэрбум төгрөг, өмнөх оны мөн үеэс 1.5 (11.5%) их наяд төгрөгөөр өсөв.

Хугацаа хэтэрсэн зээлийн өрийн үлдэгдэл 2018 оны 3 дугаар сарын эцэст 935.9 тэрбум төгрөг болж, өмнөх сараас 57.0 (5.7%) тэрбум төгрөг, өмнөх оны мөн үеэс 59.2 (6.0%) тэрбум төгрөгөөр буурлаа.

Хугацаа хэтэрсэн зээлийн өрийн үлдэгдэл нийт зээлийн өрийн үлдэгдлийн 6.6 хувийг эзэлж, өмнөх сараас 0.6 пункт, өмнөх оны мөн үеэс 1.2 пунктээр буурсан байна.

Банкны системийн хэмжээгээр чанаргүй зээл 2018 оны 3 дугаар сарын эцэст 1.2 их наяд төгрөг болж, өмнөх сараас 34.3 (2.7%) тэрбум төгрөгөөр буурч, өмнөх оны мөн үеэс 196.3 (19.0%) тэрбум төгрөгөөр өсжээ. Чанаргүй зээл нийт зээлийн өрийн үлдэгдлийн 8.7 хувийг эзэлж, өмнөх сараас 0.5 пунктээр буурч, өмнөх оны мөн үеэс 0.5 пунктээр өссөн байна.



Үнэт цаасны арилжаагаар 2018 онд эхний улиралд 255.5 тэрбум төгрөгийн гүйлгээ хийж, 273.7 сая ширхэг үнэт цаас арилжсан нь өмнөх оны мөн үеэс гүйлгээ 30.7 (13.7%) тэрбум төгрөг, арилжсан үнэт цаас 243.2 (9.0 дахин) сая ширхгээр өссөн байна.

Засгийн газрын үнэт цаасны хоёрдогч зах зээлийн арилжаагаар 2018 оны эхний улиралд 237.3 тэрбум төгрөгийн гүйлгээ хийсэн нь өмнөх оны мөн үеэс 137.5 (2.4 дахин) тэрбум төгрөгөөр өсжээ.

Хөрөнгийн зах зээлийн чиг хандлагыг илэрхийлэх ТОП-20 дундаж индекс 2018 оны 3 дугаар сард 20910.0 нэгж болж, өмнөх сараас 206.0 нэгжээр буурч, өмнөх оны мөн үеэс 8230.9 нэгжээр өсөв.

Хөрөнгийн зах зээлд үйл ажиллагаа явуулж байгаа хувьцаат компаниудын үнэт цаасны зах зээлийн нийт үнэлгээ 2018 оны 3 дугаар сард 2.6 их наяд төгрөг болж, өмнөх оны мөн үеэс 1.2 (81.0%) их наяд төгрөгөөр өссөн байна.

Төгрөгийн америк доллартай харьцах Монголбанкны нэрлэсэн дундаж ханш 2018 оны 3 дугаар сард 2395.37 төгрөг болж, өмнөх оны мөн үеэс 2.6 хувь, өмнөх сараас 0.3 хувиар чангарчээ.

Төгрөгийн юаньтай харьцах Монголбанкны нэрлэсэн дундаж ханш 2018 оны 3 дугаар сард 379.08 төгрөг болж, өмнөх оны мөн үеэс 6.3 хувиар суларч, өмнөх сараас 0.3 хувиар чангарчээ.

Төгрөгийн рубльтэй харьцах Монголбанкны нэрлэсэн дундаж ханш 2018 оны 3 дугаар сард 41.96 төгрөг болж, өмнөх оны мөн үеэс 1.3 хувь, өмнөх сараас 0.8 хувиар чангарсан байна.

Улсын нэгдсэн төсвийн тэнцвэржүүлсэн орлого, тусламжийн нийт хэмжээ 2018 оны эхний улиралд 1.8 их наяд төгрөг, зарлага, эргэж төлөгдөх цэвэр зээлийн нийт хэмжээ 1.8 их наяд төгрөг болж, улсын нэгдсэн төсвийн тэнцвэржүүлсэн нийт тэнцэл 25.8 тэрбум төгрөгийн алдагдалтай гарлаа.

Улсын нэгдсэн төсвийн тэнцвэржүүлсэн тэнцлийн алдагдал өмнөх оны мөн үеэс 229.3 тэрбум төгрөгөөр буурахад орлогын өсөлт зарлагын өсөлтөөс 16.0 пунктээр илүү байгаа нь нөлөөлжээ.

Монгол Улс 2018 оны эхний улиралд дэлхийн 160 улстай худалдаа хийж, гадаад худалдааны нийт бараа эргэлт 2.6 тэрбум америк доллар, үүнээс экспорт 1.5 тэрбум америк доллар, импорт 1.1 тэрбум америк долларт хүрлээ.

Хэрэглээний бараа, үйлчилгээний үнэ 2018 оны 3 дугаар сард улсын хэмжээнд өмнөх сараас 0.9 хувь, өмнөх оны эцсээс 3.2 хувь, өмнөх оны мөн үеэс 6.6 хувиар өссөн байна.

Эх сурвалж: NSO.mn

МЭДЭГДЭЛ

Энэхүү хэвлэл /мэдээлэл, судалгаа/ нь “Ти Ди Би Капитал ҮЦК” ХХК-ийн нэрийн өмнөөс зөвхөн өөрийн үйлчлүүлэгчид /харилцагчид/-д мэдээлэл хүргэх зорилгоор бэлтгэгдсэн ба энэ нь аливаа нэг хөрөнгө оруулалтын зөвлөгөө болон аливаа санхүүгийн хэрэгслийг худалдах, худалдан авах санал биш болно. Судалгаа/хэвлэл/-г бэлтгэх үеийн байдлаар түндэгуулагдаж буй мэдээллийн үнэн бодит байдал баталгаа гаргахгүй. Энэхүү мэдэгдэлд агуулагдаж буй мэдээллийг үйл ажиллагаандаа шууд болон шууд бус байдлаар ашигласнаас үүдэн аливаа хувь хүн, хуулийн этгээдийн үйл ажиллагаанд учирсан хохиролд “Ти Ди Би Капитал ҮЦК” ХХК хариуцлага хүлээхгүй болно.